

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх
газрын 2025 оны 06 дугаар сарын
30 өдрийн 81 дугаар албан бичгийн
1747 хавсралт



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР
2025 он**

АГУУЛГА	
НЭГ. ЗОРИЛГО	2
ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ.....	2
ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ	2
3.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үнэлгээ	2
3.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ.....	3
3.3.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтийн үнэлгээ	4
3.4.Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ..	4
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ	5
4.1.Яамны тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт.....	5
4.2.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	5
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	6
5.1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ.....	6
5.2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	6
5.3.Шударга байдлын түвшний үнэлгээ.....	7
5.4.Хэрэглэгийн үнэлгээ	7
ЗУРГАА. ДҮГНЭЛТ	8
ДОЛОО. ЗӨВЛӨМЖ.....	8

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг сайжруулж, улмаар түүний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” (цаашид “нийтлэг журам” гэх), Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримтлан Хууль зүй, дотоод хэргийн яамны 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ дээрх нийтлэг журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалаар, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын ил тод, нээлттэй байдлыг дээрх нийтлэг журмын 6.3-д заасан аргачлалаар тус тус үнэлэв.

Ерөнхий үнэлгээг нийтлэг журмын 6.5-д заасны дагуу үзүүлэлт бүрийн үнэлгээг 100 хүртэл хувиар илэрхийлэн нийлбэр үнэлгээний арифметик дунджийг харгалзах жинд шилжүүлсэн дүнгүүдийн нийлбэрийг 0.05-аар үржүүлж, 0-5 хүртэл оноонд шилжүүлэн дүгнэсэн.

Нийтлэг журмын 6 дугаар хавсралтад заасны дагуу яамдын ерөнхий үнэлгээний бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээнд орсон 3 үзүүлэлт нь нийт үнэлгээний 60 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээнд орсон 2 үзүүлэлт нь нийт үнэлгээний 20 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээнд орсон 3 үзүүлэлт нь нийт үнэлгээний 20 хувь болно.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.7, 9.8-д заасны дагуу Шударга байдлын түвшний үнэлгээг Авлигатай тэмцэх газрын, шилэн дансны хөтлөлтийг Сангийн яамны үнэлгээний дүнг үндэслэн тус тус үнэлгээнд оруулан тооцов.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус яамнаас цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн тайланд тулгуурласны зэрэгцээ бусад холбогдох баримт бичиг, статистик мэдээлэлтэй зохих харьцуулалт хийж, 2023 онд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзсэн болно.

ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үнэлгээ

Эрүүл мэндийн яаманд Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол зэрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр үүрэг чиглэл болгосон 202 шийдвэрийн 423 заалтын биелэлтэд хяналт шинжилгээ хийхэд хэрэгжилтийн дундаж 69.7 хувь “хэрэгжих шатанд” байна.

Энэ нь яамдын дунджаас 4.12 хувиар доогуур, өмнөх оны үнэлгээтэй харьцуулахад 5.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны хэрэгжилтийн хувь.

Эрх зүйн актын төрөл	Заалтын тоо	Үнэлгээ /заалтын тоо/					Үнэлгээний дундаж хувь
		Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжилт хангалтгүй	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	
		100%	70%	30%	0%	ХБ	
Монгол Улсын хууль	56	26	5	7	15	3	59.6
УИХ-ын тогтоол	64	10	31	13	4	6	61.3
УИХБХ-ны тогтоол	56	27	11	8	8	2	68.7
Ерөнхийлөгчийн зарлиг	7	-	3	3	1	-	42.8
ҮАБЗ-ийн тэмдэглэл	-	-	-	-	-	-	-
ҮАБЗ-ийн зөвлөмж	15	4	5	3	3	-	56.0
ЗГ-ын тогтоол	69	35	22	7	3	2	78.3
ЕС-ын захирамж	-	-	-	-	-	-	-
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	140	68	42	13	9	8	76.7
ЗГ-ын албан даалгавар	16	4	9	1	2	-	66.2
Нийт	423	174	128	55	45	21	69.7
Үнэлгээнд эзлэх хувь	100.0	41.1	30.3	13.0	10.6	5.0	

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Тус яам нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

Хяналт шинжилгээний дүнгээр нийт 423 заалтаас “хэрэгжилт хангалтгүй” 55, “хэрэгжээгүй” 45 заалт байна. Дээр дурдсан хэрэгжилт хангалтгүй буюу хэрэгжээгүй заалтыг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой зохион байгуулалтын арга хэмжээ авч, гүйцэтгэл, үр дүнг сайжруулахад анхаарч ажиллах (www.new.unelgee.gov.mn мэдээллийн цахим сан)

3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар, 2024 оны сүүлийн хагас жилийн хэрэгжилтийг 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн хувиар тус тус тооцож үнэлэв.

Тус яамны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтийн дундаж 48.2 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” байна.

Энэ нь яамдын дундажтай харьцуулахад 9.12 хувиар доогуур, өмнөх оны үнэлгээтэй харьцуулахад 12.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. ЗГҮАХ-ийн 2024 оны хэрэгжилтийн хувь
Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт зорилт арга хэмжээ	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					Дундаж үнэлгээ /хувь/
		Үр дүнтэй (100)	Тодорхой үр дүнд хүрсэн (90, 70)	Эрчимжүүлэх шаардлагатай (50, 30)	Үр дүнгүй (0)	ХБ	
1. Бүсчилсэн хөгжлийн бодлого	-	-	-	-	-	-	-

2.Хүний хөгжлийн бодлого	20	2	9	8	1	
3.Эдийн засгийн бодлого	-	-	-	-	-	
4.Хүний эрхийг дээдэлсэн -засаглалын бодлого	-	-	-	-	-	
2024 оны сүүлийн хагас жил	20	2	9	8	1	24.7
2024 оны эхний хагас жил	94	-	-	-	-	71.66
Хэрэгжилтийн дундаж						48.2

Эх сурвалж:Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

3.3.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтийн үнэлгээ¹

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан Эрүүл мэндийн яамны хариуцан хэрэгжүүлсэн 11 арга хэмжээний биелэлт 55.5 хувь байна.

Хүснэгт 3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх ТЖҮЧ-ийн 2024 оны хэрэгжилт

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт	Үнэлгээ (шалгуур үзүүлэлтийн тоогоор)				Дундаж үнэлгээ /%/
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
Хүний хөгжил	11	-	2	9	-	55.5
Нийт	11	-	2	9	-	55.5
Үнэлгээнд эзлэх хувь	100.0	0.0	18.2	81.8	0.0	

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Тус яамны бусад байгууллагатай буюу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран хамтран хэрэгжүүлсэн 2 арга хэмжээний биелэлт 40.0 хувь байна.

Хүснэгт 4. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх ТЖҮЧ-ийн 2024 оны хэрэгжилт /хамтран хэрэгжүүлэгч байгууллагатай/

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт	Үнэлгээ (шалгуур үзүүлэлтийн тоогоор)				Дундаж үнэлгээ /%/
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
Бүс, орон нутгийн хөгжил	1	-	-	1	-	40.0
Улаанбаатар ба дагуул хот	1	-	-	1	-	
Нийт	2	-	-	2	-	40.0
Үнэлгээнд эзлэх хувь	100.0	0.0	0.0	100.0	0.0	

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Мөн “Улаанбаатар ба дагуул хот” зорилгын хүрээнд Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран хэрэгжүүлсэн “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай, бүсчилсэн сүлжээг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана” төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

3.4.Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ²

Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан Эрүүл мэндийн яамны хариуцан хэрэгжүүлсэн 9 арга хэмжээний биелэлт 51.1 хувь байна.

Хүснэгт 5. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний биелэлт

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт	Үнэлгээ (шалгуур үзүүлэлтийн тоогоор)				Дундаж үнэлгээ /%/
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна.	9	2	2	2	3	51.1

¹ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7 дугаар хавсралтад заасны дагуу Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын жилийн үйл ажиллагааны үнэлгээнд Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ ороогүй болно.

² Монгол Улсыг хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг гаргахдаа ТЕЗ болон хөтөлбөрийн үр дүн, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын дүнгийн дунджаар ерөнхий үнэлгээнд оруулж тооцсон, тус тайланд зөвхөн арга хэмжээний үнэлгээгээр хэрэгжилтийг гаргасан болно.

Нийт	9	2	2	2	3	51.1
Үнэлгээнд эзлэх хувь	100.0	22.22	22.22	22.22	33.33	

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Тус яамны "Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна" тэргүүлэх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилга барих, "Хавдар судлалын үндэсний төвийн салбар II"-ын барилга барих, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих ажлуудыг үр дүнгүй гэж дүгнэгдсэн.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Яамны тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Тус яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө Стратегийн 7 зорилгын хүрээнд 225 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Тус гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж 61.5 хувиар үнэлэв.

Хүснэгт 5. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт (хувиар)

№	Үндсэн чиглэл	Арга хэмжээний тоо	Биелэлтийн хувь						Дундаж үнэлгээ (%)
			Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн		Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	
				100	90	70	50		
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан асуудал	12	0	9	2	-	1	-	89.2
Нийт		225	0	102	18	24	43	38	61.5
Нийт дүнд эзлэх хувь		100	0	53.3		29.8		16.9	

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 135 арга хэмжээнээс 53.3% буюу 120 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 29.8% буюу 67 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 16.9% буюу 38 арга хэмжээ үр дүнгүй гэж тус дүгнэгдсэн байна.

4.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

Тус яамны 2024 оны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2 зорилт, 7 үйл ажиллагааны хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтийн дагуу хянан үзэхэд, хэрэгжилт 72.86 хувь буюу тодорхой үр дүнд хүрсэн байна.

Энэ нь яамдын дунджаас 1.52 хувь дээгүүр, өмнөх 2023 оны үнэлгээтэй харьцуулахад 4.29 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6. Хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтийн хувь.

Зорилт	Үйл ажиллагаа	Хэрэгжилт (%)
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх	1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	100
	2. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	100
	3. Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	70
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	4. Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	90
	5. Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	0

6.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	50
7.Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	100
Хэрэгжилтийн дундаж хувь	72.86

Эх сурвалж:Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Хяналт шинжилгээн дүнгээр хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилтын дундаж 90 хувь буюу өмнөх оноос 33.34 хувиар өссөн, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын дундаж 60 хувь өмнөх оноос 17.5 хувиар буурсан байна.

ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

5.1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн 5 бүлгийн 46 шалгуур үзүүлэлт тус бүрээр Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д заасан аргачлалын дагуу хяналт шинжилгээ хийв.

Хяналт шинжилгээний дүнгээр тус яамны мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн дундаж 54.52 хувь буюу “хэрэгжих шатанд” байна.

Энэ нь яамдын дунджаас 12.91 хувь доогуур, өмнөх 2023 оны үнэлгээтэй харьцуулахад 29.48 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График 1.Мэдээллийн ил тод байдлын 2024 оны үнэлгээ.



Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Тус яамны нийтэд нээлттэй мэдээлсэн байвал зохих 46 үзүүлэлтийн 2.17 хувь буюу 1 үзүүлэлт “бүрэн хэрэгжсэн”, 65.2 хувь буюу 30 үзүүлэлт “хэрэгжих шатанд”, 6.52 хувь буюу 3 үзүүлэлт “хэрэгжилт хангалтгүй”, 17.39 хувь 8 үзүүлэлт “хэрэгжээгүй”, 8.70 хувь буюу 4 үзүүлэлт “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” гэж тус тус дүгнэгдсэн байна.

5.2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Тус яам 118 харьяа байгууллагатай ба 2024 онд шилэн дансны цахим нэгдсэн системд нэг байгууллага дунджаар 169 мэдээлэл байршуулахаас 157 мэдээллийг байршуулж, шилэн дансны хөтлөлт дунджаар 92.9 хувь гэж дүгнэгдсэн байна.

Энэ нь бусад яамдын шилэн дансны хөтлөлтийн хэрэгжилтийн дунджаас 2.61 хувь доогуур, өмнөх 2023 онтой харьцуулахад 2.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7. Шилэн данс хөтлөлтийн ерөнхий мэдээлэл, 2024 он

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Эрүүл мэндийн сайд
Харьяа байгууллагын тоо	118
Нэг байгууллагын шилэн дансанд байршуулах мэдээллийн дундаж тоо	Байршуулах Байршуулсан
	169 157
Мэдээллийг хугацаанд нь байршуулсан эсэх	Хугацаанд нь байршуулсан
	153

	Хугацаа хоцроосон	4
Хэрэгжилтийн хувь		92.9

Эх сурвалж: Сангийн яам

Дээрх хүснэгтээс үзэхэд тус яам, харьяа байгууллагуудын нэгдсэн дүнгээр шилэн дансны цахим системд мэдээллийг 4 удаа хоцроож байршуулсан байна.

5.3.Шударга байдлын түвшний үнэлгээ

Авлигатай тэмцэх газрын 2024 оны шударга байдлын үнэлгээгээр тус яам нь 100 оноо авахаас 72.85 оноо авсан байна. Энэ нь яамдын тухай жилийн дунджаас 4.25 оноогоор доогуур, өмнөх 2023 оны үнэлгээнээс 2.15 оноогоор буурсан үзүүлэлттэй байна.

д/д	Яам	2023 он	2024		Хүснэгт 8.Шударга байдлын үнэлгээ 2024 он дундаж	Өмнөх оноос өссөн /-буурсан
			ДШБҮ	ГШБҮ		
1	Эрүүл мэндийн яам	75.0	77.9	67.8	72.85	-2.15
2	Улсын дундаж	76.6	82.5	71.8	77.1	
Зөрүү		-1.6			-4.3	


Эх сурвалж: Авлигатай тэмцэх газрын 2024 оны "Шударга байдлын үнэлгээ" судалгааны тайлан

5.4.Хэрэглэгийн үнэлгээ³

Эрүүл мэндийн яамны 2024 оны үйл ажиллагааны талаарх хэрэглэгчийн үнэлгээг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2025 оны А/62 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, Төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгаа, Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, Судалгаанд оролцогчдын идэвх гэсэн 4-н үзүүлэлтээр дүгнэсэн.

Судалгааны дүнгээр: Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны үр дүнгийн үнэлгээгээр 30 онооноос 20.33 оноо буюу 67.76 хувь, төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгаанд тус яамны удирдах болон гүйцэтгэх нийт 84 албан хаагчаас 13 асуумжийн хүрээнд авсан судалгаагаар 30 онооноос 17.91 оноо буюу 59.7 хувь, судалгаанд оролцогчдын идэвх 9 оноо буюу 90.0 хувь, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, тайлагналтын байдал 30 онооноос 5.59 оноо буюу 18.63 хувь гэж тус тус дүгнэгдсэн байна.

График 2. Эрүүл мэндийн яамны Төрийн байгууллага, албан тушаалтны 2024 оны үйл ажиллагаа чанартай, хүртээмжтэй, шуурхай байдлын үнэлгээ оноогоор



³ Төрийн байгууллага, албан тушаалтны 2024 оны үйл ажиллагаа чанартай, хүртээмжтэй, шуурхай байдлын үнэлгээг авч нэгтгэв.

Тус яамны хувьд хэрэглэгчийн үнэлгээний дундаж 52.83 хувь буюу яамдын дунджаас 0.28 хувиар доогуур үзүүлэлттэй байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Эрүүл мэндийн яамны 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тус яамны ерөнхий үнэлгээ 3.29 оноо буюу 65.81 хувьтай дүгнэгдлээ. Энэ нь яамдын дунджаас 6.55 хувиар доогуур, 2023 оны өөрийн үнэлгээний дунджаас 2.18 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үнэлгээний үндсэн 3 үзүүлэлтээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дундаж 63.77 хувь, чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж 63.68 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ 72.85 хувьтай байна.

Хүснэгт 9.Ерөнхий үнэлгээ

№	Үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	75.1Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт
		Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
		Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
		Байгууллагын ил тод байдал
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Шилэн дансны хөтлөлт
		Шударга байдлын түвшин
		Хэрэглэгчийн үнэлгээ
4	Оноо	3.29
5	Ерөнхий үнэлгээ	65.81

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Үнэлгээний үзүүлэлт тус бүрийн дүнг 2023 оны үнэлгээний үзүүлэлттэй харьцуулахад бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дундаж 7.6, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж 3 хувиар тус тус өссөн, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний дундаж 15 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эрүүл мэндийн яамны ерөнхий үнэлгээнээс үзэхэд байгууллагын үйл ажиллагааг үнэлэх 9 үзүүлэлтээс хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Монгол Улсын жилийн хөгжлийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт, шилэн дансны хөтлөлт зэрэг 6 үзүүлэлт өмнөх оны үнэлгээнээс 1.7-32.2 хувиар өссөн бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, байгууллагын ил тод байдал, шударга байдлын түвшин зэрэг 3 үзүүлэлт өмнөх оны үнэлгээнээс 2.2-29.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн бодлого, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон байгууллагын гүйцэтгэлийг төлөвлөхдөө хөрөнгө санхүүгийн болон бусад шаардлагатай нөөцийг урьдчилан тооцоолж, төсөв, төсвийн төсөөллийн дагуу тодорхойлсон хязгаарлалтын хүрээнд батлагдсан аргачлалын дагуу суурь түвшин, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг

тоо болон чанараар хэмжиж болохуйц тодорхойлж, төслийг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг тайлагнаж байх;

2. Урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнгээр хэрэгжилт хангалтгүй буюу хэрэгжээгүй гэж үнэлэгдсэн зорилт, арга хэмжээ тус бүрийг хяналтад авч, хэрэгжээгүй шалтгаан нөхцөлийг тогтоох, судалгаа дүн шинжилгээ хийж, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулан, үр дүнг эргэн тайлагнах;

3. Бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинд нөхцөл байдлын дүн шинжилгээ, тухайн үйл ажиллагааны эрэмбэ дараалал, гүйцэтгэх үе шатанд тулгуурлан оновчтой, зөв тодорхойлж, төлөвлөх;

4. Бодлогын баримт бичгийн биелэлтийн явцад байнгын хяналт тавьж, биелэлт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангах;

5. Бодлогын баримт бичиг болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилсан шатны бэлтгэл ажлууд буюу судалгаа шинжилгээ хийх, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хянах, тендер шалгаруулалт, гэрээ хэлцэл хийх зэрэг ажлыг шуурхай зохион байгуулах, энэ чиглэлээр мэргэжлийн байгууллагуудын оролцоо, үйл ажиллагааны процессыг сайжруулах;

6. Бодлогын баримт бичиг болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрсэн эсэхийг тодорхой, нотлох баримтад үндэслэн үнэн зөв тайлагнаж байх;

7. Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөж, тогтоосон хугацаанд нь холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн, үнэн зөв мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг байнга хангаж ажиллах;

8. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч хувийн хэвшлийн байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах;

9. Байгууллагын мэдээллийн ил тод байдлын үзүүлэлтийг тайлагнахдаа холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур үзүүлэлтийн дагуу нотлох баримтыг хавсаргаж, вэб сайт дээрх нээлттэй мэдээллийн 5-н төрлийн 46 үзүүлэлт тус бүрийн мэдээллийг байнга шинэчилж, тухайн асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж, холбоо барих ажилтны мэдээллийг бүрэн байршуулж байх;

10. Яамны харьяа байгууллагын веб сайтын үйл ажиллагааг бүрэн ажиллуулж, цахимаар мэдээлэл авах боломжгүй иргэдэд мэдээллийн самбараас шаардлагатай мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх;

11. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн давхардлын судалгааг гаргаж, хяналтад авах, тайлагнах үйл ажиллагааг сайжруулах саналын хамт 2025 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор monitoring@ags.gov.mn хаягаар ирүүлэх.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР